

Монгол улсын их хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох
Их эв намын мөрийн хөтөлбөр

Их эв намаас дэвшүүлж байгаа хөгжлийн эрхэм дээд зорилго:

Хүндээ хүрдэг, амьдралд хүрдэг хөгжлийг бүтээх.

Хөгжлийн тулгуур зорилтууд:

- Орчин үеийн өндөр мэдлэг боловсролтойн дээр зөв, үнэн, шударга, ариун монгол хүнийг хүмүүжүүлэх
- Өндөр ёс суртахуун, өндөр хариуцлага, өндөр боловсрол, өндөр хүмүүжилтэй бөгөөд чинээлэг, аюулгүй, шударга, боловсон モンゴル нийгмийг цогцлоох
- Жинхэнэ ардчилсан, шударга бөгөөд өндөр ёс суртахуун, өндөр хариуцлага, өндөр сахилга бат, өндөр дэг журам, өндөр мэдлэг ухаан, өндөр чадвар чадамж, өндөр үлгэр дуурайлал бүхий モンゴル төр, засгийг байгуулах
- Ард түмний их эвийг үүсгэж, нэгдмэл байдлыг бий болгохын хамт монгол үндэсний ухамсар, сэтгэхүйг сэргээн нэмэгдүүлж өөрийнхөө үнэт чанарыг бүрнээ тээсэн モンゴル үндэстнийг сэргээх
- Ард түмний их эвийн үндсэн дээр нийгмийн бүхий л хүрээ, түвшинд хамтач үзэл, хамтын хариуцлагын тогтолцоог бий болгох
- Үндэсний бүхий л талын нөөц боломжин дээр тулгуурласан, үндэсний онцлогтой, олон тулгуурт, арвич хямгач, өндөр үр ашигтай, бие даасан монгол аж ахуй, モンゴル эдийн засгийг бий болгох
- Баян чинээлэг, соёлч боловсон, оюунлаг ухаалаг, эрх тааваар, эв нэгдэлтэй, эвсэг хамтач, амар тайван, аз жаргалтай モンゴル амьдралыг бий болгох
- Ухаалаг, оюунлаг, мэдлэгтэй, мэдрэмжтэй, хурдтай, хүчтэй, арвич, хямгач, үр ашигтай, эгэл даруу, цогц бүтэн モンゴル хөгжлийг бүтээх
- Эвийн хүч - хамтын хүчинд тулгуурласан орчин үеийн хөгжингүй, хүчирхэг Монгол улсыг сэргээн мандуулах.

Хөгжилд баримтлах чиг хандлага:

1990 оноос хойших 30 жилийн хугацаанд Монгол улс, үндэстний өмнө болон нийгмийн амьдралын бүхий л хүрээ, салбарт нэн даруй шийдвэрлэвэл зохих олон чухал асуудал тулгаран тулгамдсаныг мэдэхгүй хүн нэгээхэн ч үгүй билээ. Бүгд л чухамхүү үүний төлөө анхаарал хандуулж, санаа тавьж байна.

Эдүгээ энэ бүхнийг шийдвэрлэхгүйгээр, ялангуяа улс төр, нийгэм, эдийн засаг, эрүүл мэнд, боловсрол, хууль шүүх, үүрэг хариуцлага, шударга ёсны салбарт дорвитой шинэчлэл, өөрчлөлт хийхгүйгээр цаашдаа ямар ч салбарт ямар ч ажил хийгээд, их хөрөнгө санхүү зарцуулаад үр ашигтүй болох явдал улам бур газар авсаар байна. Өөрөөр хэлбэл, өнөөгийн Монгол улс, нийгмийн байдал нь **бодлогын чанартай суурь шинэчлэл, суурь өөрчлөлт хийхийг хүчтэй шаардаж байна**.

Иймд Монгол улсын их хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох Их эв намын мөрийн хөтөлбөрийн зорилго, агуулга нь бодлогын чанартай суурь шинэчлэл, өөрчлөлтөнд төвлөрсөн болно. Их эв намын мөрийн хөтөлбөр нь шинэчлэх, өөрчлөх, засаж сайжруулах, устгах гэсэн үндсэн дөрвөн хэсгээс бүрдэнэ.


I. ШИНЭЧЛЭХ:

1. Улс төрийн шинэчлэл:

- Төрийг шууд ард түмнээс байгуулдаг тогтолцоог хэрэгжүүлэх бодлогыг Монгол улсын Үндсэн хууль болон бусад хууль, тогтоомжинд тусгуулах.
- Төрийг цомхон, чадварлаг болгох бодлогыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх.
- Бүх шатны төрийн албан хаагчийг мэргэжлийн тогтмол давтан сургалттай болгох.
- Бүх шатны төрийн албан хаагчийг тусгай хөтөлбөрөөр байнга соён гэгээрүүлэх, тэдний ёс суртахуун, сахилга батыг сайжруулах.
- Орон нутгийн өөрийн удирдлагын системийг улам боловсронгуй болгох.
- Орон нутгийн бие даан оршин тогтнох чадварыг эрс нэмэгдүүлэх.

2. Нийгмийн шинэчлэл:

- Хүн төвтэй нийгмийг цогцлоох бодлогыг хэрэгжүүлэх.
- Нийгмийн тэргүүлэх чиглэлийг уул уурхай биш, боловсрол, гэгээрлийн салбар болгох бодлогыг хэрэгжүүлэх.



- Оюун санаа, эрдэм мэдлэг, авьяас чадвар, үүрэг хариуцлага, шударга үнэний үнэлэмжинд суурилсан нийгмийт байгуулах.
- Нийгэм дэх хамгийн дээд үнэ цэнэ бол эрүүл чийрэг, өндөр боловсролтой, дээд гэгээрэлтэй, хүнлэг энэрэнгүй, үнэнч шударга, эх оронч, үүрэг хариуцлагатай, бат журамтай монгол хүн байх тогтолцоог бүрдүүлэх.
- Хөрөнгө мөнгөтэй хүмүүсийн хувийн эрх чөлөөг хөхүүлэн дэмждэг хөрөнгөтний үзэл суртал, хөрөнгөтний арчилсан нийгмийн элементүүдийг халж, нийтийн эрх ашиг ба нийтийн эрх чөлөөг дээдэлдэг ард түмний арчилсан нийгмийг бэхжүүлэн хөгжүүлэх.
- Гэгээрсэн, ухамсартай хувь хүний эрх чөлөө болон нийтийн эрх чөлөөг эрхэмлэн дээдэлдэг арчилал, арчилсан нийгмийг цогцлоох.

3. Эдийн засгийн шинэчлэл:


- Хүн бүхэн үйлдвэрлэгч, өрх бүхэн үйлдвэрлэгч байх тогтолцоог бий болгох.
- Баг, сум, хороо, аймаг, дүүрэг бүхэн үйлдвэрлэгч байх тогтолцоог бий болгох.
- Уул уурхайд суурилсан эдийн засгаас олон тулгуурт эдийн засгийн бодлогыг хэрэгжүүлэх:
 - мал аж ахуйд суурилсан эдийн засаг хөгжүүлэх
 - үндэсний үйлдвэрлэлд суурилсан эдийн засаг хөгжүүлэх
 - мэдлэгт суурилсан эдийн засаг хөгжүүлэх
 - оюун ухаанд суурилсан эдийн засаг хөгжүүлэх
 - аялал жуулчлалд суурилсан эдийн засаг хөгжүүлэх
 - технологид суурилсан эдийн засгийг хөгжүүлэх.

4. Хариуцлагын шинэчлэл:

- Хүн бүр, хуулийн этгээд бүрийн нийгмийн хариуцлагыг нэмэгдүүлэх, сайжруулахын тул улам боловсронгуй хариуцлагын тогтолцоог санаачлах, хуульчлах, хэрэгжүүлэх.
- Хувийн хариуцлагын тогтолцооноос гадна хамтын хариуцлагын тогтолцоог бий болгох.
- Хувийн болон хамтын хариуцлагын цогц хууль санаачилж батлуулах.
- УИХ – ын гишүүдийн халдашгүй байдлыг хамгаалсан хуулийн заалтыг цуцлуулах.

5. Татварын шинэчлэл:

- Татварын тогтолцоог улам боловсронгуй, үр дүнтэй болгох бодлогыг хэрэгжүүлэх.
- Хүн амын орлогын албан татвар бус хүн амын татвар авдаг тогтолцоо бий болгох: хүн амыг хүүхэд багачууд, идэр залуу, ахмад үе гэсэн гурван хэсэгт ангилаад, ангилаал бүр ижил тэнцүү хэмжээний татвар төлдөг буюу насны ангилаар ялгаатай



The image shows two handwritten signatures. The first signature on the left appears to be 'Доржжавжаргал' (Dorzhjavjavgal). The second signature on the right appears to be 'Доржжавжаргал' (Dorzhjavjavgal), which is likely a duplicate or a witness signature.

мөртөө ангилал дотроо ижил тэнцүү хэмжээтэй татвар төлдөг тогтолцоог бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх.

- Тансаг хэрэглээний бараа бүтээгдэхүүний НӨАТ – ын хувь хэмжээг нэмэгдүүлэх.
- Албан татварын хэмжээг нэмэхгүй, шинээр татвар бий болгохгүй.
- Ард иргэдийг үе шаттайгаар татварын дарамтаас чөлөөлөх.

II. ӨӨРЧЛӨХ

1. Эрүүл мэндийн салбар дахь өөрчлөлт:


- Эрүүл мэндийн аливаа эмчилгээ, үйлчилгээг үнэ төлбөргүй болгох бодлогыг баримталж, эрх зүйн орчныг бий болгохын төлөө ажиллах.

2. Боловсролын салбар дахь өөрчлөлт:

- Боловсролын салбарыг гэгээрлийн салбар болгох ажлыг хууль эрх зүйн хүрээнд хийх.
- Бүх шатны боловсрол олгох үйл ажиллагааг үнэ төлбөргүй болгох бодлогыг баримталж, хууль эрх зүйн орчныг бүрдүүлэхийн төлөө ажиллах.
- Хүнийг мэргэжилтэн болгон бэлдэж буй өнөөгийн тогтолцоог хүнийг сайн мэргэжилтнээс гадна жинхэнэ хүн, жинхэнэ монгол хүн буюу зөв, үнэн, шударга, ариун, эх оронч монгол хүн болгож бэлддэг тогтолцоо болгож өөрчлөх.
- Хүнийг ажил мэргэжилд бэлдэж байгаа одоогийн тогтолцоог хүнийг ажил мэргэжилд төдийгүй амьдралд бэлтгэдэг тогтолцоо болгох.
- Хүнийг юуны өмнө хүншүүлэх, улмаар хүмүүжүүлэхэд онцгой ач холбогдолтой монгол хэл, уран зохиол, түүх, монгол уламжлалт соёл, ёс заншилтай холбоотой хичээлүүдийн заах цагийг нэмэгдүүлэх.
- Хүнийг соён гэгээрүүлэх болон иргэншүүлэхэд онцгой ач холбогдолтой монгол суу ухааны хичээлийг бүх шатны боловсролын агуулгад багтаан заах.

3. Хүнийг өөрчлөх:

- Сүүлийн 30 жилд монгол хүний хүн ёс, хүн чанар, хүн сэтгэл, хүнлэг сэтгэл, ёс суртахуун, үүрэг хариуцлага, нүнжиг жудаг, бат журам, ноён нуруу нэн ихээр алдагдаж байгаа тул монгол хүнийг дахин сургах, дахин боловсруулах, дахин хүмүүжүүлэх ажлыг өргөн далайцтай, өндөр чанартай хийх.
- Ард түмнийг бүх нийтээр нь албан журмаар соён гэгээрүүлэх.



- Уламжлал, шинэчлэлийг хослуулсан 21 - р зууны зөв, үнэн, шударга, ариун монгол хүнийг төлөвшүүлэх.
- Нийгмийн үүрэг, хариуцлагаа гүн ухамсарласан, ёс суртахуун, ёс журам, ёс жудаг, бат журам бүхий монгол хүнийг дахин хүмүүжүүлэх.
- Эв хамтач, эвсэг нийтэч, хүн чанар, хүн сэтгэл, хүнлэг сэтгэлтэй, нинжин энэрэнгүй монгол хүнийг дахин хүмүүжүүлэх.
- Эмэгтэйчүүдийн боловсрол, соён гэгээрэл, хөгжлийн түвшинг дээшлүүлэх.
- Эмэгтэйчүүдийн шийдвэр гаргах түвшинд оролцоог нэмэгдүүлэх.

4. Хууль, эрх зүй:

- Хуулийн дарангуйллын зарим илрэл, хэлбэр болсон эрүүдэн шүүлт, хэлмэгдүүлэлт, хууль бус үйл ажиллагаануудыг бүрэн халах бодлогыг хэрэгжүүлэх.
- Хууль, шүүхийн байгууллага болон түүний ажилтан, албан хаагчдыг гарцаагүй шударга ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэхийн тул хамаарах хуулиудад нэмэлт өөрчлөлт оруулах, зохих хуулийг санаачлах.
- Олон нийтийг сургаж боловсруулах, соён гэгээрүүлэх замаар гэмт хэрэгт шийтгэгдэх хүн болон хорих ангиудын тоог цөөрүүлэх бодлогыг хэрэгжүүлэх.
- Хорих ангиудын засан хүмүүжүүлэх үйл ажиллагаанд соён гэгээрүүлэх ажлыг нэвтрүүлэх.
- Хуулийн байгууллагуудын бүх шатны ажилтан, албан хаагчдад зориулсан үүрэг, хариуцлагаа ухамсарлах, ёс суртахууныг эрхэмлэх, шударга ёсыг дээдлэхэд төлөвшүүлэх тусгай зорилтот соён гэгээрүүлэх ажил хийх.

5. Шударга ёс:

- Ёс суртахууны тухай хууль санаачилж батлуулах.
- Хариуцлагын тухай хууль санаачилж батлуулах.
- Шударга ёсны тухай хууль санаачилж батлуулах.

III. ЗАСАЖ САЙЖРУУЛАХ

1. Шинжлэх ухаан, эрдэм шинжилгээ:

- Шинжлэх ухаан, технологийг Монгол улсын тогтвортой хөгжлийг хангах, амьдралын чанар, үндэсний чадамж, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, инновацийг дэмжиж үйлдвэрлэлд нэвтрүүлэх, соён гэгээрэлд суурилсан улс төр, соён гэгээрэлд суурилсан нийгэм, соён гэгээрэлд суурилсан эдийн засаг,



соён гэгээрэлд суурилсан оршин амьдрахуй бүрэлдэн тогтох нөхцлийг бий болгоход чиглүүлэн хөгжүүлэх.

- Шинжлэх ухааны онол, мэдлэгийг хялбаршуулж, олон нийтийг соён гэгээрүүлэх үндсэн арга хэрэгсэл болгох.
- Шинжлэх ухааны салбар дахь төсвийн хуваарилалтыг нэмэгдүүлэх замаар эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг чанаржуулах, үр дүнг улам нэмэгдүүлэх.

2. Соён гэгээрэл:

- Ард түмнийг бүх нийтээр нь албан журмаар байнга соён гэгээрүүлэх бодлогыг хэрэгжүүлэх.
- Нийгмийн салбарууд, мэргэжлийн салбаруудын хүрээнд тусгай хөтөлбөрт соён гэгээрүүлэх ажлуудыг тасралтгүй хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх.

3. Соёл:


- Биет болон биет бус монгол соёлын өвүүдийг хамгаалах гол арга нь ЮНЕСКО – гийн соёлын өвд бүртгүүлэх төдий явдал бус, харин үеэс үед заан сургах, дамжуулан өвлүүлэх, амьдралд байнга хэрэглэж – соёлыг амьд байлгах явдал хэмээх бодлогыг хэрэгжүүлэх.
- Монгол уламжлалт биет болон биет бус соёлын өвүүдийг бүх төрлөөр хамгаалах, судлах, сэргээх, өвлүүлэх, гадаад ба дотоодод сурталчлан таниулах ажлуудыг эрчимжүүлэх.

4. Шашин шүтлэг:

- Харийн шашны сүм хийдүүдэд мэргэжлийн хяналтын шалгалт үзлэг хийж, тавигдаж буй шаардлага болон Монгол улсын хууль, дүрэм журам зөрчсөн тохиолдолд үйл ажиллагааг шууд зогсоох.
- Монгол үндэстэн хийгээд ард түмний оюун санаа, амь нас, амьран оршихуйд сөрөг нөлөө, аюултай шашны гаж урсгалуудын үйл ажиллагааг бүрэн зогсоох.
- Аль ч шашны үйл ажиллагааг соён гэгээрүүлэх зорилгод нийцүүлэх.

5. Байгаль экологи:

- Ногоон хөгжлийн бодлого нь Монгол улсын оршихуй, хөгжихүйн тулгуур байсан уламжлалыг бүх талаар эрчимтэй сэргээх.



- Монгол улсын газар нутаг, байгаль, цаг уурын бүрэн бүтэн байдлыг бүх талаар эргэн сэргээх.
- Байгаль экологийг хамгаалах төдийгүй усны нөөц, гол мөрний урсац бүрэлдэх эх газруудыг бүрэн хамгаалалтанд авах.
- Хүн амын ундны ус, ахуйн болон бэлчээрийн малын ундны усны эх үүсвэрийг онцгойлон хамгаалах, тэдгээрийг аливаа үйлдвэрлэл, уул уурхайд ашиглуулахгүй байх.
- Байгаль орчин, газар зүй, уур амьсгалын өөрчлөлтөнд дасан зохицох үндэсний чадавхийг бүх талаар бүрдүүлж, байгалийн элдэв гамшиг, аюулт үзэгдлээс урьдчилан сэргийлэх тогтолцоог бүрдүүлэх.

6. Уул уурхай:

- Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд уул уурхайн эдийн засагт эзлэх байр суурь, нөлөөг үе шаттайгаар бууруулах.
- Ард түмний санал асуулганд үндэслэсэн уул уурхайн ашиглалтын хуваарь гаргаж хэрэгжүүлэх.
- Ашиглаж буй болон ашиглах уурхайнуудын хувьд боловсруулах үйлдвэрүүдийг бүх шатанд барьж ажиллуулах бодлогыг үе шаттайгаар хэрэгжүүлэх.

7. Мал аж ахуй:


- Мал, малчин, мал аж ахуйг хөгжүүлэх цогц бодлогыг боловсруулан хэрэгжүүлэх.
- Малын түүхий эдийг боловсруулах үйлдвэрүүдийг шинжлэх ухааны тооцоо, судалгааны үндсэн дээр маш нарийн төлөвлөгөөтэй барьж байгуулах, ажиллуулах ажлыг үе шаттайгаар хийх.

8. Газар тариалан:

- Газар тариаланг дотоодынхоо нийт хэрэгцээг бүрэн хангах хэмжээнд хөгжүүлэх.

9. Аж үйлдвэр:

- Олон тулгуурт эдийн засгийн хөгжлийн хүрээнд Монгол улсыг аж үйлдвэр - хөдөө аж ахуй - аялал жуулчлалын орон болгох бодлого хэрэгжүүлэх.
- Хүнсний ба хөнгөн үйлдвэр, боловсруулах үйлдвэр, хүнд үйлдвэрийг хурдацтай хөгжүүлэх бодлогыг улам боловсронгуй, оновчтой, үр ашигтай болгох.



10
2023

- ХАА- н үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эрчимжүүлэх тусгай бодлого боловсруулж хэрэгжүүлэх.
- Иргэдийн эрхэлж буй жижиг, дунд үйлдвэрлэлийг төрийн тусгай бодлогоор дэмжиж хөгжүүлэх.
- Дэлхийн зах зээлд нийлүүлэх экспортын бүтээгдэхүүний төрөл, тоо, чанарыг эрчимтэй нэмэгдүүлэх бодлогыг боловсруулж батлуулах.

10. Аялал жуулчлал:

- Байгалийн аялал жуулчлалыг улам эрчимтэй хөгжүүлэх.
- Үндэсний соёл, ёс заншлын аялал жуулчлалыг хөгжүүлэх.

11. Банк, санхүү:

- Банкны салбарыг олон улсын өрсөлдөөнд оруулах.
- Монгол улс болон ард иргэд өргүй байх, амьдрах бодлогыг хэрэгжүүлэх.

12. Хөдөөгийн хөгжил:

- Хөдөөгийн хүн амын орлогыг эрс нэмэгдүүлэхийн тул хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийг олон төрөл, хэмжээгээр худалдан авах хөдөө аж ахуйн биржүүдийг орон нутагт ажиллуулах.

13. Хөдөлмөр эрхлэлт:

- Энэхүү хөтөлбөрийн “Аж үйлдвэр” гэсэн хэсэгт тусгагдсан олон төрлийн аж үйлдвэрийг барьж байгуулах, ажиллуулах замаар хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх.
- Компьютер, программ хангамж, мэдээллийн технологи, хиймэл оюун ухаан зэрэг салбарт оюуны үйлдвэрлэлийг хөгжүүлэх бодлогыг боловсруулах.
- Хувиараа бизнес эрхлэлтийг бүх талаар төрийн бодлогоор дэмжих.
- Залуучуудыг малчин болоход идэвхтэй уриалж, тэднийг олноор нь малчин болгох бодлогыг хэрэгжүүлэх.

14. Нийгмийн хамгаалал:

- Хавтгайрсан халамжийн бодлогоос татгалзах.
- Одоо хэрэгжиж байгаа нийгмийн хамгааллын бүх хөтөлбөр, үйл ажиллагааг улам боловсронгуй, оновчтой, үр дүнтэй болгох.



- Иргэдийн бие даан амьдрах, амьдрал ахуйгаа бие даан авч явах чадвар болон нийгмийн нөхцлийг үе шаттайгаар сайжруулах.

15. Гэр бүл:


- Нийгмийн хамгааллын хүрээнд гэр бүлийн зөвлөлгөө өгөх төвүүдийг судалгаа, тооцооны үндсэн дээр хүртээмжтэйгээр байгуулж, ажиллуулах.
- Гэр бүлийн хүчирхийллийн асуудлуудыг шийдвэрлэхэд чиглэгдсэн соён гэгээрлийн ажлуудыг үе шаттайгаар явуулах.

16. Гадаад харилцаа:

- Хөрш орнууд болох ОХУ, БНХАУ – тай харилцах харилцан хүндэтгэлтэй, харилцан ашигтай, найрсаг харилцааг гадаад бодлогод тэргүүн зэрэгт авч үзэх.
- Дэлхийн бусад орнуудтай гуравдагч хөршийн харилцан хүндэтгэлтэй, харилцан ашигтай, найрсаг харилцааг бэхжүүлж, хөгжүүлэх.

IV. УСТГАХ

1. Монгол улс, үндэстний эрх ашиг, аюулгүй байдалд заналхийлсэн, улсаас урvasан аливаа үйл ажиллагааг таслан зогсоох.
2. Монгол улс, үндэстний эрх ашиг болон шударга ёсонд халтай аливаа үзэгдлийг таслан зогсоох.
3. Монгол улс, үндэстний эрх ашгаас дээгүүр давсан хувийн болон компанийн, хүн ёсны аливаа харилцааг таслан зогсоох.
4. Нийгмийг хүчтэй цочрол, айdas түгшүүрт автуулдаг жигшүүрт гэмт үйлдлүүдийг таслан зогсоох.
5. Нийгмийн доторх хүчирхийлэл, доромжлол, гүтгэлэг, дээрэм, булаалт, худал хэлэх, хууран мэхлэх, нэр хүндэд халдах, мансуурах, хар тамхинд донтох, биеэ үнэлэх, архидан согтуурах зэрэг хүнд гэмт үйлдлүүдийг таслан зогсоох.
6. Нийгэмд гарч байгаа гэмт хэргүүдийн тоог бууруулах.
7. Хуулийг шударгыг бусаар хэрэглэх, ашиглах явдлыг таслан зогсоох.
8. Албан тушаал, эрх мэдлээ хувийн зорилгод ашиглах явдлыг бүрэн устгах.
9. Авилгал, хээл хахууль авах явдлыг бүрэн устгах.
10. Өмч хөрөнгө ашиглах, шамшигдуулах, зувчуулах явдлыг таслан зогсоох.



11. Өмч хөрөнгийг үр ашиггүй зарцуулдаг, үрэн таран хийдэг бүх явдлыг таслан зогсоох.
12. Эрх мэдэл, албан тушаал, өмч хөрөнгө, цаг хугацаа, үйл хэрэг, улс орны эрх ашгийг хулгайлах явдлыг таслан зогсоох.

Боловсруулсан:

Их эв намын дарга:

Намын ерөнхий нарийн бичгийн дарга:

Намын нарийн бичгийн дарга:



3.Бат – Отгон

Ж.Тайванжаргал

Б.Отгонбаяр

2020.04.10

М.Овчинников
Ж.Тайванжаргал
Б.Отгонбаяр



ИХ ЭВ НАМД

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас: 26-04-37, Факс: 51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2020.04.21 № 1236
танай -ны № -т

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн
талаарх дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.17, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасан Үндэсний аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох “Их эв нам”-аас ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянаж, дүгнэлт гаргалаа.

Үүрэг хариуцлагын талаарх мэдээлэл

Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвсэл нь сонгуулийн мөрийн хөтөлбөрөө Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-д нийцүүлэн боловсруулж, санхүүгийн тодорхой эх үүсвэр шаардсан зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын дүнгийн хамт Төрийн аудитын байгууллагад ирүүлж, Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.5-д заасны дагуу дүгнэлт гаргуулах үүрэг хүлээнэ.

Сонгуулийн мөрийн хөтөлбөрийн дүгнэлтийн үндэслэл

Үндэсний аудитын газар нь Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцох нам, эвслийн сонгуулийн мөрийн хөтөлбөрийг хянан үзэхдээ “Төрийн аудит MNS 6817 - 1 : 2020” Тулгуур зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 6 : 2020” Нийцлийн аудитын зарчим, “Төрийн аудит MNS 6817 - 8 : 2020” Нийцлийн аудитын стандартыг удирдлага болгон Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хууль, Төсвийн тогтвортой байдлын тухай хууль, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Монгол Улсын нэгдсэн төсвийн 2020 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2020-2022 оны төсвийн төсөөллийн тухай хууль болон холбогдох байгууллагаас авсан тайлан, судалгаа, мэдээллийг тус тус шалгуур болгон авч үзсэн.

Дүгнэлт

“Их эв нам”-ын Улсын Их Хурлын 2020 оны ээлжит сонгуульд оролцохор ирүүлсэн сонгуулийн мөрийн хөтөлбөр, түүнд орсон зорилт, арга хэмжээ нь Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3. дахь хэсэг, “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан тусгай шаардлагад тус тус нийцсэн байна.

“Их эв нам”-ын мөрийн хөтөлбөр / 10 / хуудас/-ийг хавсаргав.

Хувийг: Сонгуулийн Ерөнхий хороонд

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР

Д.ЗАНДАНБАТ